





# БЭЛД, АНХААР, ЭХЭЛ!

Чамд Залуу эрэгтэйчүүд эсвэл Залуу эмэгтэйчүүдийн ангид дэвшихээр бэлдэхэд чинь туслах зарим санааг дор өгүүлэв. Чи дараалан дөрвийг авч чадах уу?

 <p>Судартаа зориулан судрын хавчуурга хий.</p>	<p>Хүүхдийн хэсгээс явахдаа санаа зовниж байж магадгүй хэн нэгэнтэй ярилц.</p>	 <p>Дуртай судрын эшлэлээ гэртээ өлгө.</p>	<p>Гэрчлэлээ бусадтай хуваалц.</p>
<p>Бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчөөсөө <i>Өсвөр үеийнхний бат бөх байдлын төлөө: Сонголт хийхэд туслах хөтөч</i>-ийн хуулбарыг авахыг хүс.</p>	<p>Анги руугаа авч явах дэвтрээ чимэглэ.</p> 	<h2>Чөлөөт орон зай</h2>	<p>Хүүхдийн хэсгийн багшид талархлын захидал бич.</p> 
<p>Ариун сүмийн зөвшөөрлийн бичгийн ярилцлагын асуултуудыг унш.</p>  <p><small>(Чи тэдгээрийг 2022 оны 11-р сарын <i>Найз</i> сэтгүүлийн 37-р хуудас-аас олох боломжтой.)</small></p>	<p>Залуу эрэгтэйчүүдийн эсвэл Залуу эмэгтэйчүүдийн анги ямархуу байдаг талаар хэн нэгнээс асуу.</p>	<p>Ангийн найзаасаа шинэ анги руу хамт орохыг хүс.</p>	<p>Залуу эрэгтэйчүүд эсвэл Залуу эмэгтэйчүүдийн ангиас юу хүлээж байгаагаа бич.</p>
<p>Залуу эмэгтэйчүүд эсвэл Залуу эрэгтэйчүүдийн удирдагчтай танилц.</p>	<p>Залуу эрэгтэйчүүд эсвэл Залуу эмэгтэйчүүдийн ангиас сурахыг хүсэж буй гурван зүйлээ бич.</p> 	<p><i>Өсвөр үеийнхний бат бөх байдлын төлөө</i> сэтгүүлийн нийтлэлүүдийг унш.</p>	<p>Шинэ удирдагчаасаа ангийн үйл ажиллагааны талаар асуу. Тэдгээрийг хуанлидаа оруулж тэмдэглэ.</p> 

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КОЛЛИН МАДДЭН

## ЗАЛУУ ЭРЭГТЭЙЧҮҮД БА ЗАЛУУ ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ДЭВШИН ОРОХ НЬ

Ирэх жил чи 12 нас хүрэх үү? Сэтгэл хөдөлгөх зарим зүйлийг доор оруулаа.

### Шинэ сэтгүүл

*Өсвөр үеийнхний бат бөх байдлын төлөө* сэтгүүл нь *Найз* сэтгүүлтэй адил хэдий ч залуу эмэгтэй, эрэгтэйчүүдэд зориулагдсан юм! Уг сэтгүүл Есүс Христийг дагадаг яг чам шиг дэлхий даяарх өсвөр үеийнхний түүхүүдээр дүүрэн.

### Сонголт хийхэд туслах хөтөч

*Өсвөр үеийнхний бат бөх байдлын төлөө: Сонголт хийхэд туслах хөтөч* нь зөвийг сонгоход чамд туслах товхимол юм. Энэ нь чамд Есүс Христийг дагаж, ариун сүмд орохоор бэлдэхэд туслах асуулт, хариултуудыг агуулдаг.



### Нэмэлт үйл ажиллагаанууд

Залуу эрэгтэй, эмэгтэйчүүдийн ангиудад та нар тойрог, салбарынхаа бусад өсвөр үеийнхэнтэй хөгжилтэй үйл ажиллагаа явуулж болдог. Чи мөн шинэ зүйл сурч, авьяас чадвараа хөгжүүлэх зорилгуудыг тавих замаар хүүхэд, өсвөр үеийнхний хөтөлбөрөө үргэлжлүүлж болно.